

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 7 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 7-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 959 болж, 2014 оны мөн үеэс 91 хүнээр, өмнөх сарынхаас 171 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 50.99 хувь буюу 489 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 903 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 436 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 37.84 хувь буюу 165 нь эмэгтэйчүүд байв.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 7 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 331 ажилгүй иргэний 28.70 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 25.38 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 21.45 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 8.16 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 2.42 хувь нь шилжин суурьшсан; 2.42 хувь

нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1.81 хувь нь цэргээс халагдсан; 1.21 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.91 хувь нь байгууллага татан буугдсан; 0.91 хувь нь орон тооны цомхтголд орсон; 1.06 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 6.04 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 7 сард НДШ-ийн орлого 8.4 тэрбум ₮ болж төлөвлөгөө 87.55 хувь болж, төлөвлөгөөг 16 сум 3.01-28.12 хувиар давуулан биелүүлж, Батсүмбэр, Баян, Баянжаргалан, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Угтаал, Эрдэнэ, Зуунмод сумд 6.26-50.69 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого

114.5 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 15.86-27.98 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжид 21.2 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.3 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.3 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 268740 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 34.70 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 22.84%; тэтгэмжийн даатгалын сангийн 98.31%; эрүүл мэндийн даатгалын сангийн 103.23%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 250.80%; ажилгүйдлийн даатгалын сангийн 145.68%-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 8 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 50555 хүнд олгож, 7.1 тэрбум ₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 4.8 хувь 2312 хүнээр өсч, зарцуулсан мөнгөний хэмжээ 4.8 хувь 332.2 сая ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 114430 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.8 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 27.5 хувийг халамжийн тэтгэвэр; 9.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.9 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.4 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 3.8 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.9 хувийг алдар цолтой ахмадуудад

үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 7 сард 8768 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.6 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 7 сард 721 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 75 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар.




Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 7-н сард нялхсын эндэгдэл 8 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 3-ээр өсөв.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үетэй адил байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



2015 оны эхний 7 сард нийт гарсан халдварт өвчнөөр 884 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 590 хүнээр өслөө. 2014 оны мөн үеэс цусан суулга 3.3 дахин, салхин цэцэг 2 дахин, бруцеллёз 2 дахин, тэмбүү 22.4 хувь, сүрьеэ 15.6 хувь, бусад өвчлөл 7.1 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 98 байгаа бол: Зуунмод 329, Баянжаргалан 204 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Төв аймгийн 2015 оны 8 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

- агаарын дундаж температур 18-21 градус дулаан буюу Өндөрширээт орчмоор дулаан, Мөнгөнморьтоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 29-38 градус буюу Бүрэн, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Лүн, Жаргалант, Угтаал, Заамар, Борнуур, Залуучууд орчмоор 32-38 градус хүрч халсан байхад нутгийн зүүн хойд хэсэг болох Мөнгөнморьт, Эрдэнэ, Зуунмод

орчмоор 29-31 градус хүрч дулаарсан байв.

-шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 2-10 градус дулаан буюу Заамар, Баянцагаан орчмоор 9-10 градус, бусад нутгаар 2-8 градус, Эрдэнэ, Мөнгөнморьт орчмоор 2 градус дулаан ажиглагдсан байв.

-бүх нутгаар сарын нийлбэр хур тунадас 11,1-116,6 мм, нутгийн өмнөд хэсгээр бага үүнээс Дэлгэрхаанд 11,1 мм хамгийн бага нь, нутгийн хойд хэсэг болон зарим газраар арай ахиу, үүнээс хамгийн их нь Жаргалант, Залуучууд, Заамар, Батсүмбэр, Борнуурт 71,7-116,6 мм бороо оржээ.

-салхины их хурд нийт нутгаар 4-14 м/с, борооны өмнө түр зуур 18-23 м/с, Эрдэнэсантад 23 м/с хүрч ширүүслээ.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

-агаарын дундаж температур нь бүх нутгаар 1-3 градус орчмоор дулаан

-өдрийн хамгийн их температур нь бүх нутгаар 1-6 орчим градусаар дулаан ажиглагдсан

-шөнийн хамгийн бага температур нь бүх нутгаар 2-7 градус орчмоор дулаан ажиглагдсан

-сум тус бүрээр тунадасны нийлбэрийг гаргаж үзэхэд өмнөх оны 8-р сараас ихэнх нутгаар ахиу Дэлгэрхаан, Баянжаргалан, Алтанбулаг орчмоор 1-5 мм орчмоор бага, Эрдэнэд ойролцоо бороо оров.

- салхины их хурд нийт нутгаар 4-14 м/с, борооны өмнө түр зуур 18-23 м/с, Эрдэнэсантад 23 м/с хүрч ширүүслээ.

2015 ОНЫ ЕСДҮГЭЭР САРЫН ЦАГ
АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Төв аймгийн Агаарын температурын сарын дундаж нь нутгийн баруун хэсгээр 4-9 градус, бусад нутгаар 9-14 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Хүйтрэх үе: Гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр хүйтэрч уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн өдөртөө 3-8 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, цочир хүйтэрнэ, өдөртөө 7-12 градус дулаан байна.

Сэрүүсэх үе: Нэгдүгээр арав хоногийн дунд үеэс сэрүүсч сүүлчээр нь уулархаг нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 6-11 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4 градус дулаанаас 1 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 11-16 градус дулаан байна.

Дулаарах үе: Нэгдүгээр арав хоногийн эхэн болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус, өдөртөө 17-22 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 8-13 градус, өдөртөө 22-27 градус дулаан байна.

Бусад хугацаанд: Уулархаг уулархаг нутгаар шөнөдөө 0-5 градус хүйтэн, өдөртөө 13-18 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус, өдөртөө 17-22 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим байна. Дундаж нь Сүмбэр, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Батсүмбэр орчмоор 30-43 мм, бусад нутгаар 17-30 мм.

Нэгдүгээр арав хоногийн эхээр нутгийн хойд хэсгээр, дунд үеэр зарим газраар бороо орно. Дуу цахилгаантай. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар бороо, уулархаг нутгаар хур тунадас орно. Хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар, дунд үеэр нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр зарим газраар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд үе болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үе, эцсээр зарим газраар 16-18 м/с хүртэл ширүүсч шороон шуурга шуурах төлөвтэй.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН
НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

9 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, нутгийн баруун хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар орчим орохоор байна.

Одоогийн байдлаар бэлчээрийн ургамлын ургалтын байдал нийт нутгийн 60 гаруй хувьд сайн, 40 орчим хувьд гандуу байна.

9 дүгээр сард зарим нутгаар бага зэрэг дулаан, хур тунадас багавтар орохоор байгаа нь ургац хураах болон хадлан тэжээл бэлтгэх ажилд таатай нөлөөлөхөөр байна.

2015 ОНЫ АРАВДУГААР САРЫН
ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ


Энэ сард агаарын температурын сарын дундаж нь уулархаг нутгаар 0-5 градус хүйтэн, бусад нутгаар 0-5 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард ихэнх нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.



1.5 Гэмт хэрэг


Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 564 гэмт хэрэг бүртгэгдэж 525 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1.7 тэрбум ₮-ийн хохирол учирлаа.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 7 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 47.5 хувь нь хулгай, 25.5 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний хэрэг, 14.9 хувь нь замын осол, 2.5 хувь нь танхай дээрэм, 1.4 хувь нь хүний амийн хэрэг 7.9 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Батсүмбэр, Заамар, Баяндэлгэр, Борнуур сумдад 10000 хүнд 352-141 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (63)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 8 хэргээр буурлаа.

Зуунмод суманд 31 эмэгтэй, 657 эрэгтэй нийт 688 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 33 хүнээр буурлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 7 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 589 гүйцэтгэх хуудсанд нийт 1.92 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 32 гүйцэтгэх хуудсанд ногдох 529.4 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 557 гүйцэтгэх хуудасны 1.39 тэрбум ₮-өөс 214 хуудасны 422.2 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 38.42 хувь, үнийн дүнгээр 30.32 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 6.43 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 16.13 нэгжээр тус тус буурлаа.

II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 7 сард кассын орлого 212.6 тэрбум ₮, кассын зарлага 212.3 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.4 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 7 сарын байдлаар 118.7 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 627.1 сая ₮-өөр өслөө.

2015 он гарсаар бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 74.0 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Иргэдийн хувийн хадгаламжинд 7 сарын 31-ний байдлаар 40.3 тэрбум ₮ байна. Харилцах дансны үлдэгдэл 7 сарын 31-ны байдлаар 260018 иргэний 12.9 тэрбум ₮

боллоо. ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.37 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.91 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 7 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 6.1 тэрбум, зарлага 35.0 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 105.35 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, нохойн албан татвар, хүү торгуулийн орлого, төсөвт газрын өөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2014 оны мөн үеэс 6.7 хувь буюу 441.7 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 82.8 хувийг татварын, 15.6 хувийг татварын бус, 1.5 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 1.8 нэгжээр буурч, татварын бус орлого 0.8 нэгжээр өсч, хөрөнгө борлуулсны орлого 1.0 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 8.1 тэрбум ₮ болж аймгийнх 5.1 тэрбум ₮ буюу 64.69 хувь, сумынх 1.0 тэрбум ₮ буюу 12.52 хувь, улсынх 2.0 тэрбум ₮ буюу 24.79 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2014 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 29.85 хувь буюу 191.8 сая ₮-өөр өсч 834.6 сая ₮ болж, авлага 57.47 хувь буюу 47.8 сая ₮-өөр өсч 131.1 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 5.9 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 107.39 хувиар биелэгдлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.0 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 137.06 хувь биелж, Сэргэлэн, Батсүмбэр, Зуунмод,

Борнуур, Баянчандмань сумд 41.73-13.37 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 5.1 тэрбум ₮ болж 100.70 хувь биелж Баянжаргалан, Цээл, Заамар, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянцогт, Эрдэнэ, Угтаал, Өндөрширээт, Архуст, Сэргэлэн, Лүн, Жаргалант, Борнуур, Эрдэнэсант сумд төлөвлөгөө 38.13-0.32 хувиар тасалдууллаа.



II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 7 дугаар сарын 0.33 хувийн өсөлтийн 0.24 нэгж (72.89%) нь хувцас, бөс бараа; 0.14 нэгж (44.07%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0.13 нэгж (40.08%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн; 0.08 нэгж (24.53%) нь эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн; 0.02 нэгж (12.09%) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ. Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 0.29 нэгжээр буурсан нь ерөнхий индекс харьцангуй бага өсөхөд нөлөөлжээ.

Зураг II.4



Зураг II. 5

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 7 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	0.33	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БҮС УНДАА	-0.29	-89.74%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.24	72.89%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.13	40.08%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.14	44.07%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.08	24.53%
07. ТЭЭВЭР	0.00	1.09%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.02	7.08%



II.5 Аж үйлдвэр

2015 оны эхний 7 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 22.62 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 1.8 дахин буюу 14.67 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Заамар, Баянчандмань, Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянцагаан сумд 40.44-2.02 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 93.86) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.₮-р
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/


АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2014 YII	2015 YII	2014 I-YII	2015 I-YII	Дүн дараах % Percentage share to total		2015/ 2014%
					2014 I-YII	2015 I-YII	
Нийт дүн	1,189.30	7,513.08	7,945.58	22,623.30	100.0	100.0	284.7%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	473.98	7,223.31	3,928.37	19,303.59	49.44%	65.33	491.4%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing	714.59	289.20	3,028.14	2,316.57	38.11	10.24	76.5%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	0.73	0.58	989.06	1,003.14	12.4	4.43	101.4%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хувцас үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал

үйлдвэрлэл, нийтлэх хэвлэх дуу бичлэг хийх үйл ажиллагаа, цахилгаан, дулаан уур үйлдвэрлэл өмнөх оноос 3.9 дахинаас-1.4 хувь буюу 15.37 тэрбумаас -5.4 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 7 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 4.43, боловсруулах үйлдвэрлэл 10.24, ашигт малтмал олборлолт 85.33 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, хувиар




II.6 Барилга

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 оны эхний 7 сард 2.0 тэрбум ₮-ийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 25.95 хувь буюу 702.4 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 71.63 хувь нь инженерийн барилга байгууламжид; 21.51 хувь нь орон сууцны бус барилгад; 6.86 хувь нь орон сууцны барилгад ногдож байна. Энэ нь 2014 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 29.42; орон сууцны барилгын ажил 15.27 пунктээр тус тус буурч, инженерийн барилга байгууламжийн ажил 44.68 пунктээр өсөв.

Зураг II.8

Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөгөөр



II.7 Холбоо


Холбоо ашиглалтын орлого оны эхний 7 сард 121.4 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 57.7 сая ₮ болж, нийт орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.08 хувь буюу 38.5 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 55.0 сая ₮ болсон ба нийт орлогын 77.42 хувь нь хүн амд үйлчилсний орлого байна. Нийт орлогын 22.57 хувийг албан бичгийн,

13.80 хувийг зорчигчдын, 63.63 хувийг бусад орлого бүрдүүллээ.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Улсын бүртгэлийн хэлтэс

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 7 сард нийт 776 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 39; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 257; бэлэглэлийн гэрээ 37; худалдах, худалдан авах гэрээ 41; өв залгамжлал 5; барьцааны гэрээ 77; бусад бүртгэл 320 тус бүр бүртгүүлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2015 оны эхний 7 сард нийт 131 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 92; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 19; гишүүдэдээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 4; Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/ 1; хоршоо 5; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 8 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2015 оны 7 сарын мэдээгээр 217 аж

ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 45; гишүүн нэмэгдсэн 50; данс нэмэгдсэн 18; дүрэм шинэчилсэн 5; дахин гэрчилгээ авсан 25; удирдлага өөрчлөгдсөн 10; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 17; дүрмийн сан нэмэгдсэн 6; нэгдсэн 1; хаяг өөрчлөгдсөн 13; татан буугдсан 23; нэр өөрчлөгдсөн 3; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.

Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2015 оны эхний 7 сарын мэдээгээр нийт 150 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 350; үүнээс тохирлын гэрчилгээ 295, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 55; цулын хэмжүүр 719, үүнээс жин 583, туухай 136, автомашины жин 1; эзлэхүүний хэмжүүр 238, үүнээс түгээгүүрийн хошуу 177, сүмбэн метр 33, усны тоолуур 11; шигэн бүтээгдэхүүн хэмжих хэрэгсэл 10, мерник 1, цахилгааны хэмжүүр 1315, үүнээс нэг фазын тоолуур 1185, гурван фазын тоолуур 130 тус бүр баталгаажуулсан байна.